



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/381

Улаанбаатар хот

┌ Албан тушаалын тодорхойлолт ┐
шинэчлэн боловсруулах үүрэг бүхий
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулалт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 2.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /А.Мөнгөн/-д даалгасугай.

3. Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахад шаардагдах зардлыг үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

4. Албан тушаалын тодорхойлолтыг 2019 оны 12 дугаар сард багтаан шинэчлэн боловсруулж, Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Н.Золжаргал/-д үүрэг болгосугай.

5. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ




Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2019

115050001199

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 29 -ны өдрийн #1387 тушаалын хавсралт



Албан тушаалын тодорхойлолт
шинэчлэн боловсруулах үүрэг бүхий
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

А.Мөнгөн Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

Д.Итгэл Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

С.Ариунжаргал Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

М.Мандах Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

Ж.Сувданзаяа Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Б.Оюун-Эрдэнэ Захиргаа санхүүгийн хэлтсийн Програм хангамж хариуцсан мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Н.Золжаргал Захиргаа санхүүгийн хэлтсийн Ахлах, хүний нөөцийн мэргэжилтэн